



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 206 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/04 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/176 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Төвийн зарим үйл ажиллагааг цахимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай программ, системийг нэвтрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн салбарт нэвтэрсэн үндсэн болон дэд системд, Төвийн лабораторийн үйл ажиллагааг интеграц хийх, программ хангамжуудтай мэдээлэл солилцох, шаардлагатай программ хангамж, системийг нэвтрүүлж, ажлын үр дүнг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөрт багтаан танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (У.Өнөрсайхан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг холбогдох журмын дагуу гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба (Э.Номин)-нд даалгасугай.


ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

1813171049

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2024 оны .04. дүгээр сарын 05.-ны өдрийн
А/24 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: У.Өнөрсайхан (Лавлагаа, лабораторийн албаны дарга)

Гишүүд:

Э.Номин (Захиргааны албаны дарга)

Э.Бүрдэнэжаргал (Хуулийн зөвлөх)

Б.Номин-Эрдэнэ (Санхүү, хангамж, нөөцийн албаны Эдийн засагч)

Э.Очиржамаа (Захиргааны албаны Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

О.Даариймаа (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Статистикч)

Б.Лхагвасүрэн (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Сүлжээний инженер)

Б.Мөнгөнбагана (Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Амьтан судлаач)

Б.Цэцгээ (Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Халдвар судлагч)

Д.Отгонсүрэн (Лавлагаа, лабораторийн албаны Лаборант)

Нарийн бичиг:

Н.Ураншагай (Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл технологийн албаны Программ хангамжийн инженер)

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн
2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн
А/24 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах мэрэгжилтэн	Хугацаа
1	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Гэрээлэлтийн газартай уулзалт хийх	Э.Номин У.Өнөрсайхан Н.Ураншагай	IV/29-IV/30
2	Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний холбогдох хууль, дүрэм журам судлах	Э.Бүрдэнэжаргал Э.Очиржамаа	IV/29-IV/30
3	Хүний өвчлөлийн оношилгоо, шинжилгээний өртөг тооцоход шаардлагатай зүйлийн жагсаалт гаргах (өвчин тус бүрээр)	У. Өнөрсайхан Д.Отгонсүрэн	IV/29-V/3
4	Мэрэгчийн дуудлагын оношилгоо шинжилгээний жагсаалт гаргах	У. Өнөрсайхан Д.Отгонсүрэн	IV/29-V/3
5	Төвийн тусламж үйлчилгээний мэдээ, мэдээллийн урсгалын зураглал гаргах	О.Даариймаа	IV/29-V/3
6	2021-2023 оны зоонозын өвчний статистик мэдээ гаргах	О.Даариймаа	IV/29-V/3
7	2021-2023 оны хүний өвчлөлийн эмнэлэгийн тусламж үйлчилгээ авсан газар, байгууллага, дуудлага бүртгэгдсэн газар, байгууллагын бүртгэл мэдээ гаргах	О.Даариймаа	IV/29-V/3
8	2021-2022 оны мэрэгчийн дуудлагын статистик мэдээ гаргах	О.Даариймаа	IV/29-V/3
9	2021-2022 оны мэрэгчийн дуудлага өгсөн газар, байгууллагын бүртгэл, Төвөөс очиж үйлчилсэн газар, байгууллагын бүртгэл мэдээлэл гаргах	Б.Мөнгөнбагана	IV/29-V/3
10	Тусламж, үйлчилгээний хүрээнд системийн шинжилгээ хийх, процессийн зураглал гаргах	Н.Ураншагай Б.Лхагвасүрэн О.Даариймаа Б.Цэцгээ	IV/29-V/6
11	Эрүүл мэндийн салбарт нэвтэрсэн системүүд болон программ хангамжийн судалгаа, дүн шинжилгээ хийх	О.Даариймаа Н.Ураншагай Б.Лхагвасүрэн	IV/29-V/6
12	Лабораторийн шинжилгээний нэгж өртөг тооцох	Б.Номин-Эрдэнэ	V/3-V/15
13	2021-2023 оны мэрэгчийн дуудлагын зардал тооцох	Б.Номин-Эрдэнэ	V/3-V/15
14	Эрүүл мэндийн даатгалын системд холбох	Н.Ураншагай Б.Лхагвасүрэн Э.Очиржамаа О.Даариймаа	V/15-V/30

15	Шаардлгатай систем, программ хангамжийг нэвтрүүлэх	У. Өнөрсайхан Н.Ураншагай Б.Лхагвасүрэн О.Даариймаа	V/15-V/30
16	Үр дүнг тайлагнах	У. Өнөрсайхан Н.Ураншагай	V/31

ХЯНАСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

У.ӨНӨРСАЙХАН

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ

Зураг

Н.УРАНШАГАЙ